

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2021 ОНЫ 06 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

2021 оны 07 дугаар сарын 01

Дархан

“Нийтийн эзэмшлийн орон сууцын засвар, шинэчлэлт /Дархан-Уул, Дархан сум/” ажил 57 хувийн гүйцэтгэлтэй тул 370,024,000.0 төгрөгийн санхүүжилтийг “Вилла бридж” ХХК-д, зураг төсвийн үнэ 29,976,000.0 төгрөгийн санхүүжилтийг “Васт сайз констракшн” ХХК-д;

Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дархан-Уул, Дархан сум, Өргөө баг/ ажил 80 хувийн гүйцэтгэлтэй тул 233,323,457.0 төгрөгийн санхүүжилтийг “Дархан трейд” ХХК-д, зохиогчийн хяналтын зардалд 1,215,252.0 төгрөгийн санхүүжилтийг “Турнинг” ХХК-д, захиалагчийн хяналтын зардалд 3,498,531.5 төгрөгийн санхүүжилтийг “ДХББЗГ” ОНӨААТҮГ-д, 3,498,531. төгрөгийн санхүүжилтийг Барилгын хөгжлийн төвд;

Орон сууцын хороолол доторх гэрэлтүүлэг, шинэчлэл /Дархан-Уул, Дархан сум, 4, 5, 8, 9, Өргөө баг/ ажил 76 хувийн гүйцэтгэлтэй тул 248,546,944.0 төгрөгийн санхүүжилтийг “Лэд сити” ХХК-д, захиалагчийн хяналтын зардалд 5,020,685. төгрөгийн санхүүжилтийг “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-т, зураг төсвийн үнэ 6,500,000.0 төгрөгийн санхүүжилтийг Е.Лхүндэвт тус тус олгосон.

Шинэ Хуучин Дарханыг холбосон авто замаас 27-р байрны дэргэдэх 4-н замын уулзвар хүртэлх авто зам, инженерийн шугам сүлжээ ажлын гүйцэтгэлд 609,843,779.0 төгрөгийн санхүүжилтийг ОДНД ХХК-д

Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 50,000,000.0 төгрөг, Хонгор сумын ОНХС-ын дансанд 47,014,567.0 төгрөг, Шарын гол сумын ОНХС-ын дансанд 23,428,346.0 төгрөг тус тус олгосон.

“Шарилжгүй Дархан” төслийн хүрээнд шарилжны хор, бараа материал нийлүүлэх ажилд 9,970,000.0 төгрөгийн санхүүжилтийг “И Эйч Эс Эм” ХХК-д олгосон.

Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил /Дархан сумын 14-р баг/-ын зураг төсвийн зардалд 15,000,000 төгрөгийн санхүүжилтийг “Автокад” ХХК-д,

Төрийн архивын сан хөмрөгийн өрөөний засвар /Дархан сум/-ын ажлын гүйцэтгэлд 28,000,621 Өсөх буянт тулга ХХК-д тус тус олгосон.

“Аймгийн төвийн авто замын их засвар, шинэчлэл /Дархан-Уул, Дархан сум, 4, 5, 8, 9, Өргөө баг/” “Цахимбар инженеринг” ХХК-ийн гүйцэтгэж буй 1.9 тэрбум төгрөгийн гэрээт ажлын 51.0 хувийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулж, ЗТХЯам-д, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.

“Төрөх эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх /Дархан-Уул, Дархан сум/ Багц-3” төсөл арга хэмжээний УТХО2021-01/01 дугаартай 389,800,000.0 /Гурван зуун наян есөн сая найман зуун мянган/ төгрөгийн төсөвт өртөгтэй “Си Ай Ти” ХХК-ийн гүйцэтгэж буй гэрээт ажлын 100 хувийн гүйцэтгэл

“Нийтийн эзэмшлийн орон сууцын засвар, шинэчлэлт /Дархан-Уул, Дархан сум/” төсөл арга хэмжээний УТХО2021-01/02 дугаартай 797,035,748.0 /Долоон зуун ерэн долоон сая гучин таван мянга долоон зуун дөчин найман/ төгрөгийн төсөвт өртөгтэй “Вилла бридж” ХХК-ийн гүйцэтгэж буй гэрээт ажлын 57 хувийн гүйцэтгэл

Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 2 дахь үе шат /Дархан-Уул, Дархан сум, 6, 7 дугаар баг/ төсөл арга хэмжээний УТХО2021-01/03 дугаартай 2,142,590,927.0 /хоёр тэрбум нэг зуун дөчин хоёр сая таван зуун ерэн мянга есөн зуун хорин долоо/ төгрөгийн төсөвт өртөгтэй “Дархан АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэж буй гэрээт ажлын 8.0 хувийн гүйцэтгэлийг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газарт тус тус хүргүүлсэн.

УТХО-с нийт 17 төсөл арга хэмжээ хэрэгжихээс 17 төсөл арга хэмжээний бичиг баримтыг ОНӨГ-т хүргүүлж, тендер шалгарсан 11 хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан.

ОТХО-с нийт 40 төсөл арга хэмжээ хэрэгжихээс 38 төсөл арга хэмжээний бичиг баримтыг ОНӨГ-т хүргүүлж, тендер шалгарсан 19 хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан.

ОНХС-с нийт 10 төсөл арга хэмжээ хэрэгжихээс 10 төсөл арга хэмжээний бичиг баримтыг ОНӨГ-т хүргүүлж, тендер шалгарсан 5 хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан.

Замын сангаас нийт 2 төсөл арга хэмжээ хэрэгжихээс 2 төсөл арга хэмжээний бичиг баримтыг ОНӨГ-т хүргүүлж, тендер шалгарсан 2 хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан.

Энэ онд эцсийн байдлаар 86,6 хувь буюу 148944 толгой хээлтэгч төллөж, 148978 толгой төл хүлээн авч төл бойжилт 99,0 хувьтай байна. Мөн нийт малын 0,4 хувь буюу 1604 толгой мал зүй бусаар хорогдсон байна. Үүнд: адуу 35, үхэр 252, хонь 755, ямаа 562 толгой тус тус хорогдсон. Үүнээс өвчнөөр үхэр 3, хонь 15 толгой байна.

ХХААХҮЯамнаас 2021 онд “Мал бүртгэлжүүлэх, ээмэгжүүлэх” аян, Аймгийн засаг даргын 2021 оны А-1/143 тоот захирамжийн дагуу 4 суманд үржүүлж байгаа бог малын хээлтүүлэгчийг 13 цэгт нийт 1361 толгой хээлтүүлэгчийг суурилсан бөгөөд Хонгор, Шарын гол сумдад 366 толгой хээлтүүлэгч үзлэг ангилалтад хамруулахад ХХААГ-аас хамтран зохион байгуулсан бол аймгийн Мал эмнэлгийн газрын лабораторт 2021 оны 6-р сарын 24-ны байдлаар 809 хээлтүүлэгч малын цусны дээжийг шинжлэх ажлыг хийгдэж байна.

Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд Орхон сумын Ноёнхонгорт 15 газарт гахайн өрхийн аж ахуй эрхлэх хороолол байгуулах чиглэлээр 20 газарт цэг тавиад байна. Мөн хөтөлбөрийн хүрээнд “Дархан эрчимжсэн загвар аж ахуй” төслийг 4 сумын 6 өрхөд хэрэгжүүлэхээр Аймгийн засаг даргын зөвлөл болон Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн нийт 200.4 сая төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлээд байна.

Хонгор сумын Хар бэлчирт үржүүлж буй Сэлэнгэ үүлдрийн үхрийн үржүүлгийн ажил цаашид авах арга хэмжээний талаар аймгийн Засаг даргын

орлогчоор ахлуулсан ажлын хэсэг хуралдаж шийдвэрлэсний дагуу ажлын хэсэг газар дээр нь ажиллаж дүгнэлт гаргасан байна. Уг ажлын хэсэгт Аймгийн ХОХБТХ, ОНӨГ, МЭГ, ХХААГ болон малын УСҮТөв хамтран ажилласан.

Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 өвөлжилтийн бэлтгэл хангуулах 23 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулсан, мөн 2020-2021 Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтыг даван туулсан мэдээллийг аймгийн Захирагчийн ажлын албанд хүргүүлж ажиллаа.

Өвөлжилт, хаваржилтын хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас Дэлхийн банкны санхүүжилтээр Үндэсний статистикийн хорооны 2020 оны мал тооллогын бүртгэлд бүртгэгдсэн тус аймгийн 4 сумын 1323 малчин өрхөд 100,000 мянган төгрөг олгохоор шийдвэрлэсний дагуу 4 сумын 63 малчин өрхийн дансны мэдээллийг ХХААХҮЯамны Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлээд байна.

Монгол Улсын засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоолоор батлагдсан “Хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу тус аймаг 4 сумын 386 малчинд ноосны урамшуулал олгохоор тооцоог ХХААХҮЯаманд хүргүүлсэн. Одоогийн байдлаар 4 сумын нийт 314 малчны урамшуулал шилжсэн бөгөөд бусад 72 малчдын залруулга гүйлгээний алдаа засварлаж ХХААХҮЯамны Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлээ.

Энэ сард нийт 11083 ш арьс шир бэлтгэсэн байна. Адууны арьс 5.0 мянган төгрөг, үхрийн шир үнэ 3.0-5.0 мянган төгрөг, ямааны арьс 0.5 төгрөг, хонины арьс өлөнтэйгээ 4.5 мянган төгрөг байна. Ноос 1кг нь 1500 төгрөгийн үнэтэй 52.5тн бэлтгэсэн байна. Модон материал зүсмэл 295м³, түлээний мод 385м³ бэлтгэсэн байна.

Ажлын байрыг дэмжих хөнгөлөлттэй зээлээс аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 566 иргэн, 132 аж ахуйн нэгжид 41.16 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 3 хувийн хүүтэй 3 жилийн хугацаатай олгож, 7 аж ахуйн нэгжид 1.7тэрбум төгрөгийн батлан даалт гаргаж, 2503 ажлын байр хадгалагдлаа.

Дархан-Уул аймаг Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн хүрээнд бий болсон үйлдвэр, аж ахуйн нэгжийн судалгааг гарган хүргүүлээ. Судалгаанд Хөгжлийн банкны хөрөнгө оруулалт 47.150 тэрбум төгрөг, ОУБ-ын төслөөс 840.0 сая төгрөг, ОНХС-10.0сая төгрөг, ЖДҮХС-930.0сая төгрөг, СХС-аас 173.0 сая төгрөгийн санхүүжилтээр 18 үйлдвэр цех 2017-2021 онд шинээр байгуулагдаж, 165 ажлын байр бий болсон байна. Эдгээрээс 15 үйлдвэр үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. 1 үйлдвэр ковидын улмаас тоног төхөөрөмж саатаж, 1 цех түр зогсолттой байна.

СХС-ийн зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг шинэчлэхээр мэдээллийн санд шивэлт хийж тулгах, зээлээ хугацаандаа төлөөгүй зээлдэгч нартайгаа холбогдож мэдэгдэл өгөх, программын тулгалтыг хийх зэрэг сумын мэргэжилтнүүдтэй хамтран ажилласнаар мэдээллийг нэгтгэж, төв серверт урьдчилсан байдлаар дамжууллаа. Хагас жилийн байдлаар нийт 222 иргэн аж ахуйн нэгжээс муу түүхтэй 90, эргэлзээтэй 15, хэвийн бус 11, хугацаа хэтэрсэн 27, хэвийн ангилалтай 77 зээлдэгч байна.

Зээлийн батлан даалтын сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж буй Дархан Илч ЗБНөхөрлөл, Хос-Анар ХХК, Хайрхан түшиг ХХК-тай батлан даалтын сангийн 220.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг банкаар дамжуулан олгож, гэрээг байгууллаа.

Хүнсний боловсруулах 59 хүнсний үйлдвэр, Орхон сумын 13, Хонгор сумын 20, Шарын гол сумын 33, Дархан сум 245 хүнсний дэлгүүрийн үнэ, бүтээгдэхүүний үлдэгдлийн мэдээг 7 хоног бүрийн 1, 4 дахь өдөр, нийт 46 удаа тогтмол авч,

хангамжийг хоногоор тооцож, ХХААХҮЯ, аймгийн Онцгой байдлын газарт 46 дахь удаагаа хүргүүлэн ажиллав. 2021.06.24-ний байдлаар хангамж тооцоход малын мах 5.11, гурил 1449.8, гурилан бүтээгдэхүүн 2.97, сүү, сүүн бүтээгдэхүүнээр 11.34, төмс 17.5, хүнсний ногоо 11.4, будаа 21.05, тос 37.08, элсэн чихэр 105.9, давс 110.4, өндөг 1.8, савласан цэвэр ус 1.1, цай 2.04 хоногийн нөөцтэй байна.

Дархан меат фүүдс ХХК нийслэлийн хүн амын хэрэгцээнд нөөцийн мах нийлүүлж байгаа ба хангамж тооцохдоо агуулах дахь махны хэмжээг оруулаагүй болно. Аймагт үйл ажиллагаа явуулж буй 3 гурилын үйлдвэрт буудайн үлдэгдэл нийт 51079.6 тонн, хивэг 4273.9 тн үлдэгдэлтэй байна. Тээвэр Дархан ХХК-ийн хүнсний захын махны тасагт мал, мах бэлтгэгч нар нийт 333.9 тн мах нийлүүлснээс 233.7 тн борлуулагдсан байна. Үүнээс 2-р сард 44.2т, 3-р сард 40.5т, 4-р сард 27.6т, 5-р сард 48.7т, 2021.06.(01-24)-ны өдөр 56.2т мах борлуулсан. 2021.06.24-ний өдөр 2.68т мах борлуулж, 1.49т үлдэгдэл мах байна.

Мах хонь хөлдүү 9500, шинэ 10000, ястай 13000-14000, цул 12000, ямаа шинэ 8000, ястай 11000, цул 12500, адуу шинэ 8000, ястай 12000, цул 12000, үхэр тарган 10000-12000, туранхай 8500-9000, ястай тарган 16000, туранхай 13000, цул тарган 16000-18000, туранхай 15000-18000 төгрөгийн ханштай байна.

Гурилын үйлдвэрүүдэд импортлогч орны хорио цээрийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт хийх удирдамжийн дагуу МХЕГ, ХХААХҮЯ, гурил үйлдвэрлэгчдийн холбооноос ажлын хэсэг Дархан –Уул аймагт байрлах Өег гурил ХХК, Өгөөж гурил ХХК, Улаанбаатар гурил ХХК, Дархан гурил тэжээл ХХК-дад 2021.06.24-25-ны өдрүүдэд Төрийн хяналт шалгалтын тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Ургамал хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилт, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын шаардлага хэрхэн хангаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой ажиллаж байна.

Ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн судалгааг 5-р сард гаргаж, ХХААХҮЯ-д цахимаар хүргүүлэн ажилласан. Үүнд Ажиллаж байгаа болон түр зогссон үйлдвэр, цехийг хамруулсан ба гурил үйлдвэрийн 6, хүнсний ногоо боловсруулах болон савлах 6, жимсний шүүс үйлдвэрлэх 1, ургамлын тосны 1, цайны идээ, эмийн ургамлын 1, гурилан бүтээгдэхүүний 38 үйлдвэр цехийн судалгааг гаргалаа. Судалгаагаар тулгамдаж буй асуудалд ажлын орон тоо байгаа хэдий ч ажиллах хүн хүч дутмаг, ажил хийх сэтгэл хандлага байхгүй, мэргэжлийн хүний нөөц хомс гэсэн байна.

Аймгийн хэмжээнд тариалалт 04-р сарын 23-нд эхэлж өнөөдрийн байдлаар улаан буудай 16571 га-д, төмс 525,5 га, хүнсний ногоо 1446,1 га, тосны ургамал 3807 га-д тариалалт хийж, тариалалтын явц 06-р сарын 22-ны байдлаар 118,2 хувьтай байна.

6 дугаар сард хур тунадас ихтэй байгаагаас голын түвшин нэмэгдэж Орхон суманд төмс, хүнсний ногоо тариалсан 280 га талбайд үерт урсаад байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Хүлэмж” төслийг боловсруулан Засаг даргын зөвлөлийн хурлаар батлууллаа.

Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх тухай хуралд 1. Хугацаа сунгах 2, эрх шилжих 9, талбайн хэмжээнд өөрчлөлт орох 4, газар ашиглах 1, газар эзэмших 3, эрх сэргээх 11, гэрээ, гэрчилгээ шинэчлэх 2, 15-р баг 8-р хэсэгт байршил, хаяг өөрчлөгдөж байгаа 2, өмчилсөн газрын талбайн хэмжээнд өөрчлөлт орж байгаа 10 иргэний материалыг хуралд танилцуулав.

Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Гео од” ХХК-ний хийж гүйцэтгэсэн доорхи ажлыг шалгаж хүлээн авсан. Үүнд:

- Дархан сум. 5 дугаар баг “Дэд бүтэцийн хөгжил-Баянзүрх, Дархан, Сэлэнгэ төсөл” гудамжны гэрэлтүүлгийн ажил. /улаан шугам/
- Хот доторхи гэрэлтүүлгийн шинэчлэл /улаан шугам/
- “Дархан өргөө” политехникийн коллежийн сургалт дадлагын барилга /улаан шугам/

Хаягийн зургийн дагуу 8 иргэн, 3 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 2 дугаар багийн нутаг Хүйтэний голын эх “Бичигт хад” гэх газарт үйл ажиллагаа явуулж буй “Бичигт Хад Майнинг” ХХК нь тусгай зөвшөөрөлтэй талбайгаас хэтрүүлэн ашигт малтмал хайж олборлолт явуулсан гэх 201800389 дугаар хэрэгт шинжээчээр шинжилгээ хийлгэх тухай мөрдөгчийн тогтоолд заасан асуултын дагуу хариуг Цагдаагийн газарт хүргүүллээ.

1968 оны 1:100 000-ны масштабтай байр зүйн зурагт суурилан зурагласан Дархан-Уул аймгийн хилийн цэсийн “Хараа” голын голдиролоор зурагдсан хэсэгт голын голдирол өөрчлөгдсөнөөс үүдэлтэй алдаа гарсан байдаг. Дархан-Уул аймгийн хэмжээнд дээрхи нэршлээр нэрлэгдсэн /голоор/ хэсэгт мод үржүүлэг, жимс жимсгэнэ, амаралт, сувилалын зориулалтаар газар олголт хийгдэж байгаа бөгөөд одоогийн байдлаар газрын эзэмшил, ашиглалтын явцад хүндрэл үүссэн тохиолдол гарсан эсэх судалгааг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.

2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 2021.06.14-ний өдрийн байдлаар тайлангаа гаргаж, тайлангийн үр дүнг сумын газрын даамлуудад танилцуулж, цаашид анхаарах асуудлыг албан бичгээр хүргүүллээ. 2021 оны эхний хагас жилийн байдлаар 6759 хүчинтэй гэрээнд ногдол, нэхэмжлэл үүсгэхээс 6587 гэрээнд ногдол, нэхэмжлэл үүсгэж төлөвлөгөөний гүйцэтгэл 97.4 хувьтай байна. Газрын төлбөрийн орлого 2021.06.14-ний өдрийн байдлаар 541.6 сая төгрөг төвлөрсөн байна.

**2021.06.14-ний байдлаар газрын төлбөрийн ногдуулалт,
нэхэмжлэл үүсгэсэн байдал:**

	Дархан	Орхон	Хонгор	Шарын гол	Нийт
Нийт ногдуулалт	4110	630	2120	254	7,114
Цуцлагдсан	25	1	3	2	31
Шинэ төлөвтэй	66	68	347	15	496
Нийт гэрээний тоо	4019	561	1770	237	6,587
Нэхэмжлэлийн тоо	9824	1198	4010	474	15,506
Мөнгөн дүн	1,134,085,999	22,252,719	264,908,657	4,795,549	1,426,042,924

Сумын нэр	Орлогын хэмжээ /2021.05.30-ны байдлаар/ Татвараас авсан мэдээлэл	Төлөгдсөн нэхэмжлэлийн тоо
Дархан /аймаг/	193,626,369	2,001
Дархан /сум/	136,903,213	1,733
Орхон	8,235,956	244
Хонгор	27,140,943	695
Шарын гол	2,513,789	56
Аймгийн хэмжээнд	368,420,270	4,729

Тулгат шийр ХХК-ний хүсэлтийн дагуу Хонгор сумын нутаг дэвсгэрт байрлах үйлдвэр дээр очин технологийн заавар, тоног төхөөрөмжийг үзэж, асуумжийн дагуу баримт бичгийг шалган заавар зөвөлгөө өгч ажиллаа. Барилга архитектур корпораци итгэмжлэгдсэн лабораторийн 2021.05.28-ны КБХЭ 24/21, 2021.06.02-ны КБХЭ 25/21 тоот шинжилгээний бичгийг үндэслэн Тусгай зөвшөөрлийг сунгуулах боломжтой гэж үзэн Тодорхойлолтыг БМҮХолбоонд 2021.06.17-ны 370 тоотоор хүргүүллээ.

Идэрхайрхан ХХК-ний хүсэлтийн дагуу Хонгор сумын нутаг дэвсгэрт байрлах үйлдвэр дээр очин технологийн заавар, тоног төхөөрөмжийг үзэж, асуумжийн дагуу баримт бичгийг шалган заавар зөвөлгөө өгч ажиллаа. Барилга архитектур корпораци итгэмжлэгдсэн лабораторийн 2021.06.07-ны 285/21 БДЛ, 2021.06.07-ны 286/21 БДЛ тоот шинжилгээний бичгийг үндэслэн Тусгай зөвшөөрлийг сунгуулах боломжтой гэж үзэн Тодорхойлолтыг БМҮХолбоонд 2021.06.17-ны 371 тоотоор хүргүүллээ.

Дэбүт ХХК-ний хүсэлтийн дагуу Тосгон, Үйлдвэрийн районы нутаг дэвсгэрт байрлах үйлдвэр дээр очин технологийн заавар, тоног төхөөрөмжийг үзэж, асуумжийн дагуу баримт бичгийг шалган заавар зөвөлгөө өгч ажиллаа.

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, сумдын мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг шалгах, ойн санд үйл ажиллагаа явуулдаг ойн нөхөрлөлүүд, түймрийн эргүүлээр ажиллаж байгаа иргэдэд заавар чиглэл өгөх ажлыг ОБГ, СДОАнгитай хамтран 6,02-ны өдөр Орхон, Хонгор сумын ЗДТГазар, 14 ойн нөхөрлөл, 6 түймрийн эргүүлтэй уулзаж 100 гаруй сэрэмжлүүлгийн материал, гарын авлага тараалаа.

2021 онд БОХНСАХЗардлаар үүргэн шүршигч багаж ашиглан химийн аргаар тэмцлийн ажил явуулах талбайд хортон шавжийн голомт болон тархалтын тоймчилсон судалгааг 06.03-ны өдөр СДОА, Орхон сумын ЗДТГ, Хонгор сумтай хамтран зохион байгууллаа.

Шарын гол сумын иргэн Ц.Жаргалсайхан “Ногоон Дархан” төслийн хүрээнд нарс модны 30 ширхэг нарс модны суулгац хандивласныг “Ногоон паспорт-Ногоон төгөл”, байгууллагын тохижилтод зориулж тарих ажлыг 2021.06.04-ны өдөр СДОАнгитай хамтран зохион байгууллаа.

Ойжуулалт, ойн зурвас байгуулсан, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулсан ажлын ажлын тайлан илтгэх хуудсыг бичиж, санхүүгийн баримтыг бүрдүүлсэн.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2022 онд ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх ажил хэмжээний төсвийн төслийн санал өглөө.

“Ногоон Дархан” төслийн хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг гаргаж, танилцуулгыг бэлтгэлээ.

“Ногоон Дархан” төслийн хүрээнд худалдан авсан мод, бутыг хүлээлгэн өгөх ажлын комиссыг ажиллуулах тухай албан бичгийг ХОХБТХэлтэст хүргүүлж, бараа материалыг хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулав.

Дархан сумын 3 цэцэрлэг болон иргэн Б.Энхбаяр нарын санаачилгаар Хараа голын эрэг дээр "Эко төгөл"-ийг цаашид арчлан хамгаалах талаар гэрээний төсөл боловсруулж байна.

ЭИХХЦХХ: 16 ААН-ийн 10774,9 т бодис бараа бүтээгдэхүүнд 18 удаагийн хяналт хийж, 163 дээж авч, 13 ургамлын импортын гэрчилгээ, 4 ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, 3 мал эмнэлгийн гэрчилгээг олгон, 8 гэрчилгээ баталгаажуулан хяналтаас чөлөөлж ажилласан.

ОХУ-аас импортлосон 9800 т хүнсний улаан буудай, 67,5 тэжээлийн овъёос, Америкийн нэгдсэн улсаас импортлох тарималын 13 дээжэнд хяналт хийсэн. Польш улсаас импортлогдсон 9 т чихэрнээс 3 дээж авч МХГ-ийн лабораторид хүргүүлсэн. Испани, БНХАУ, ОХУ-аас импортлосон 60 т 1 төрлийн хромын сульфат, 254,6 т 1 төрлийн эмульссолит-П-А-20, 18,750 т 10 төрлийн арьс ширний идээлэгч бодис, 130 т аммиакын шүү, 64,45 т ургамал хамгаалалын бодисыг хяналтаас чөлөөлж ажилласан.

-120 т хивэг, рапс130 т

-дулааны аргаар боловсруулсан 25 т хонины мах, 50 т үхрийн мах, 5,6 т эсгий бүтээгдэхүүнд тус тус хяналт тавьж ажилласан.

Алтанбулаг боомтоор орж ирсэн 2 ТИР машин 20 т бараа бүтээгдэхүүн Дархан-Уул аймагт буулт хийхэд 1 удаагийн хяналт тавьж, халдваргүйтгэлийг мал эмнэлгийн газраар хийлгэсэн.

Нийт давхардсан тоогоор 59 аж ахуй нэгж, 10 иргэний хүсэлтээр 871 дээжинд 1952 үзүүлэлтээр шинжилгээ хийж гүйцэтгэсэн.

ОДНД ХХК-ийн барьж байгаа Хүслийн хотхон чиглэлийн 1,1 км авто замын барилга угсралтын ажил, Цахимбар инженеринг ХХК-ийн 8-р багийн хороолол доторхи авто замын засвар шинэчлэтийн ажил, Дархан АЗЗА ТӨХК-ийн барьж байгаа 25-р хороолол-6-р баг чиглэлийн 1,1 км авто замын барилга угсралтын ажил, ажилуудад урьдчилан сэргийлэх хяналт хийсэн. Шалгалтаар тус компаниуд авто замын засварын жишиг техникийн шаардлага, ЗЗБНБД-ийн баримталж ажиллаж байна. Баян брижд ХХК-ийн нийтийн орон сууцны 2 лифт, Дархан Өргөө-6 кинотеатрын 2 лифт, иргэний эзэмшилд байдаг 1 манипуляторт краны техникийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт хийсэн.

МХЕГ-ын даргын баталсан 01/38 дугаартай удирдамжийн дагуу 11 ААНБ-т урьдчилан сэргийлэх хяналт хийж зураг төслийн боловсруулалт, материалын чанар, угсралтын ажлын гүйцэтгэлийг шалгалаа. Шалгалтаар бетоны цутгалтын технологи зөрчсөн 2, өргийн ажлыг чанаргүй гүйцэтгэсэн 2, зөвшөөрөлгүйгээр ажил гүйцэтгэсэн 1 зөрчил дутагдал илэрч, 100% арилгуулсан. 1 ААНБ-т барилгын ашиглалтын тухай улсын байцаагчийн дүгнэлт гарган хүргүүлсэн.

МХЕГ-ын даргын баталсан 01/97 дугаартай удирдамжийн дагуу арматурын угсралт, хадгалалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналтыг 6 ААН-ийг хамруулан гүйцэтгэлээ. Шалгалтаар угсрагдаж байгаа арматур зэвэрсэн, талбайд хураагдсан арматур хучлагагүй, дэргүй байсан 5 зөрчлийг арилгууллаа.

МХЕГ-ын даргын баталсан 01/65 дугаартай Цацрагтай ажиллагчдын мэргэжлийн шарлагын тунд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай удирдамжийн дагуу 9 ААН-д шалгалт хийж 12 зөрчил илрүүлэн 8 заалттай 2 албан шаардлага хүргүүлсэн.

МХЕГ-ын даргын баталсан 01/53 дугаартай удирдамжийн дагуу шинээр буюу сэргээн үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдэд урьдчилан сэргийлэх хяналтыг Хөдөлмөрийн, Нийгмийн хамгааллын болон Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид 1 ААНБ-д хийж, 24 заалттай хамтарсан албан шаардлага өгсөн. Мөн 1 ААНБ-д шалгалт үргэлжилж байна.

МХЕГ-ын даргын баталсан 01/24 дугаартай Уурын болон ус халаалтын зуух ашиглагчийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай удирдамжийн дагуу Дулаан Шарын гол ТӨХК, 6-р сургуулийн нийт 2 халаалтын зуухуудад шалгалтыг хийсэн. Шалгалтаар тус зуухууд БОНБҮнэлгээ хийлгүүлсэн. 2021 онд хэрэгжүүлэх БОМТ-гүй үйл ажиллагаа явуулж байна. 1 зуух үнс баригчтай, орчны хяналт шинжилгээг хийлгүүлсэн байна. Шалгалт үргэлжилж байна.

МХЕГ-ын даргын баталсан 01/69 дугаартай Геологи хайгуулын судалгаанд цацрагийн үүсгүүр ашиглаж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагад урьдчилан сэргийлэх шалгалт хийх удирдамжийн хүрээнд 1 ААНБ-д шалгалт хийхэд нийт 6 зөрчил илрүүлэн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан.

МХЕГ-ын даргын баталсан 01/83 дугаартай “Газрын тос, шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн тээвэрлэлт, тээврийн хэрэгслийн техникийн аюулгүй байдал, баталгаажуулалтад урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу 2 ААН-ийн үйл ажиллагаанд хамтарсан шалгалт хийхэд нийт 4 зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Шалгалт үргэлжилж байна.

МХЕГ-ын даргын баталсан 01/10 дугаартай “Ашигт малтмалыг хууль бусаар олборлох эрсдэлээс урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу 7 ААН-ийн үйл ажиллагаанд хамтарсан шалгалт хийж, 7 зөрчил илрүүлэн, зөрчлийг арилгах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Шалгалт үргэлжилж байна.

Аймгийн Засаг даргын баталсан Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, ашиглалтын байдалд хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Мон маг ХХК, МНЖОйн ХХК, Майн тех бластинг ХХК, УЦУОША, ДТҮ ХК, Шарын гол ХК-ийн тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахуудад хамтарсан шалгалтыг хийсэн.

Шалгалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг агуулахын бүртгэлтэй тулгалт хийн тоолоход зөрчил илрээгүй. Майн тех бластинг ХХК, МНЖОйн ХХК бичиг баримтын бүрдүүлэлтийг дутуу бүрдүүлсэн байгаад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хамтарсан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

Хүнсний худалдаа эрхлэгч 22 ААН, 50 иргэн нийт 72 объектыг хамруулан урьдчилан сэргийлэх шалгалт хийж, нийт 149 зөрчил илрүүлж 124 буюу 83.3 хувийг арилгуулсан. Шалгалтаар хадгалах хугацаа хэтэрсэн 11 нэр төрлийн 64 ширхэг 139220 төгрөгийн бүтээгдэхүүнийг дотоод хяналтаар устгалд оруулж, 1 нэр төрлийн 20 ширхэг 51.400 төгрөгийн бүтээгдэхүүнийг буцаан татан авалт хийлгэж, 15 хоолны газарт хэрэглэгдэж байсан 18 нэр төрлийн 31 хүнсний түүхий эд бүтээгдэхүүн, сав баглаа боодлын баталгаажилтыг хангуулсан.

Урьдчилан сэргийлэх шалгалтаар илрүүлсэн зөрчил арилгуулалт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.1%-иар өссөн байна.Шалгалтын дүнгийн талаар RGB телевизэд ярилцлага өгсөн.

МХЕГ-ын даргын баталсан 2021 оны 01/93 дугаар удирдамжаар 5 ААН-д урьчлан сэргийлэх хяналт шалгалт хийж 14 зөрчил илрүүлж 71.4%-ийг нт шалгалтын явцад арилгуулсан. Нийт хугацаа дууссан 3 ААН-ийн 1 нэр төрлийн 35 хайрцаг тамхийг дотоод хяналтаар нь устгасан. г

МУ-ын Ерөнхий сайд, МУ-ын Ерөнхийлөгчид нэр дэвшигчид /3 нэр дэвшигч/ Дархан-Уул аймагт ажиллах үеэр байрлах байр, хүнсний аюулгүй байдал, иргэдтэй уулзалт хийх байрны эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөд урьдчилан сэргийлэх шалгалт хийж, хоолны газар, зочид буудлын орчноос агаарын 12, арчдасны 69, унд, ахуйн усны 5, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний 29 дээж авч шинжлүүлэхэд эрүүл ахуй аюулгүй үзүүлэлтийн шаардлага хангасан.Шалгалтаар нийт 8 зөрчил дутагдал илрүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчлийн 7 буюу 87.5%-ийг шалгалтын явцад арилгууллаа.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаа зохион байгуулагдахтай холбогдуулан Дархан сумын 32 хэсгийн хорооны санал авах байранд хяналт тавьж Монгол улсын Засгийн газрын 2021 оны 152 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллах талаар МХГ-ын 2021.06.07-ны өдрийн 1/197 тоот албан бичгээр Аймгийн Сонгуулийн хороонд тайланг хүргүүлсэний дагуу аймгийн Сонгуулийн хорооноос 2021.06.08-ны өдрийн 26 тоот албан бичгээр хариу ирүүлсэн. Хяналт шалгалтын дүнд УОК-оос ирүүлсэн Монгол улсад бүртгэлгүй халдваргүйтгэлийн бодисыг БОАЖС, ХХААХҮС, ЭМС-ын 2021 оны А/52,А-42,А/71 дүгээр хамтарсан тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан бодисын жагсаалтад орсон бодисоор хангуулж, 5 хэсгийн хорооны санал авах байранд сонгогч хооронд 1.5м зай барих тэмдэглэгээ байршуулж, хэсгийн хороо тус бүрийн санал авах байранд тусгаарлах өрөө гаргуулж, хэсгийн хорооны санал авах байранд ажиллах эрүүл мэндийн ажилтнуудыг ЭМГ-ын 2021.06.07-ны өдрийн А/98 дугаар тушаалаар томилуулсан. Түр журмын хэрэгжилтийг дунджаар 93%-иар хангуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед 2021.06.09-ний өдөр хяналт тавьж ажиллах хуваарийг МХГ-ын даргаар батлуулан нийт 33 албан хаагч хяналт тавьж ажилласан.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 01/42 тоот удирдамжаар Хонгор сумын 2 дугаар баг, зулзагын гол орчимд байрлах 7 амралтын газрын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт хийж, гүний худагнаас нийт 9 дээж авч МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлэхээр хүргүүлсэн.

МХЕГ-ын даргын 2021 оны 01/52 дугаар удирдамжаар батлагдсан тохиолдлын ойрын хавьтал нийт 8 иргэнийг 2021.06.10-ны өдөр Дархан зочид буудалд тусгаарлах байрны эрүүл ахуй, хоол хүнсний аюулгүй байдал УОК-ын даргын 2021 оны 43 дугаар тушаалаар батлагдсан тусгаарлан ажиглах байранд тавигдах шаардлагыг хангуулан тусгаарлах арга хэмжээ авсан.

2021.06.12-ны өдөр аймгийн Шуурхай штабын хуралд оролцож коронавируст халдварын үүссэн нөхцөл байдлын улмаас тусгаарлан ажиглах байр бэлтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж 4 зочид буудлын захирал эзэдтэй уулзаж Дархан зочид буудлын 49 өрөө, 60 орны бэлэн байдлыг хангах үүрэг өгсөн.

2/Баар, караокены үйл ажиллагаа нээгдэхтэй холбоотой УОК-ийн даргын 2021 оны 41 дүгээр тушаалын хэрэгжилтийн дагуу нийт 14 аж ахуйн нэгжийн баар, караоке, хоолны газрын бэлтгэл бэлэн байдлыг шалгахад 92.8% нь цэвэрлэгээ халдваргүйтгэл хийсэн, 85.7% нь сэжигтэй тохиолдлыг түр тусгаарлах өрөө гаргасан, 100% гар халдваргүйжүүлэгч бодисоор хангагдсан, QR код байршуулсан байна. Халдвар хамгааллын дэглэмийн шаардлагыг мөрдөж ажиллах талаар үүрэг, мэргэжлийн зөвлөгөө өгсөн.

Баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж тохирлын гэрчилгээ олгохоор шийдвэрлэгдсэн 1 аж ахуйн нэгжийн 1 нэр төрлийн бүтээгдэхүүн, 5 аж ахуйн нэгжийн 2 нэр төрлийн 5 үйлчилгээний газар нийт 6ш тохирлын гэрчилгээг олгож, гэрээ байгуулан ажиллалаа.

“Дархан meat фүүдс” ХХК, “Таймлэсс” ХХК-ийн мах, эсгий бүтээгдэхүүн экспортлох хүсэлтийн дагуу тухай бүр үнэлгээг хийж, 55 т хагас боловсруулсан үхрийн мах, 25 т хатаасан махыг БНХАУ руу, 21444 ш эсгий бүтээгдэхүүнийг Норвеги улс руу экспортлохоор 5 ш тохирлын гэрчилгээг олгов.

7 ААН, 2 төрийн байгууллага 4 иргэний нийт 54,1кг буюу 39ш гулдмай хайлж сорьцолсоноос 53,2кг 39ш гулдмайд сорьцын баталгаа олгосон.

1 аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу 29 ширхэг стандартаар үйлчилсэн байна. 5 иргэн, аж ахуйн нэгжид Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946:2019, Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1 : 2019 зэрэг стандартын зөвлөгөөг өгч ажилласан.

1. Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/39 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсгийн гишүүд батлагдсан удирдамжийн дагуу 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн аймгийн Орон нутгийн өмчит 15 хуулийн этгээдэд газар дээр нь очиж эд хөрөнгийн Улсын үзлэг, тооллогыг явуулсан. Цар тахилтай холбоотойгоор 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн эд хөрөнгийн Улсын үзлэг, тооллогын ажлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн хурлаар “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих сан байгуулах үйл ажиллагааны журам батлах тухай” тогтоолыг батлуулсан.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 7,611.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 41, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 3.482.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 418.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 135.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3, Япон улсын засгийн газрын өвсний үндэс хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих /142.361 доллар/ 405.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, **нийт 12,054.2 сая** төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй **57** төсөл арга хэмжээний худалдан авалтыг **88 хувийн гүйцэтгэлтэй, 241.6 сая** төгрөгийн хэмнэлт үр ашигтай зохион байгуулан ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, Барилга хот байгуулалтын яамнаас 3,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3, Боловсрол шинжлэх ухааны яамнаас 1,060,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4, Соёлын яамнаас 5,000,0 төгрөгийн төсөвт өртөгтэй, 1, Зам тээвэр хөгжлийн яамнаас 41,044.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 4 төсөл, арга хэмжээ, Эрүүл мэндийн яамнаас 486.0 сая төгрөгийн 1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 107.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, Биеийн тамир спортын хорооноос 3,500.0 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй 1, **нийт 54,697.5** сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй, **17 төсөл, арга хэмжээ** тус тус эрх шилжигдэн ирснийг **94 хувийн гүйцэтгэлтэй, 706.7 сая** төгрөгийн хэмнэлт, үр ашигтай зохион байгуулан ажиллаж байна.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР